



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Г Тогтоолд нэмэлт, 7
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага”-ын 3.1.10 дахь заалтын “50%” гэснийг “20%”, 3.1.13 дахь заалтын “Бусад хөрөнгө 30%” гэснийг “Санхүүгийн болон үйл ажиллагааны түрээс 10%; 5%” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага”-д дор дурдсан агуулгатай 1.6.9, 3.3 дахь заалтуудыг нэмсүгэй:

1/ 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 9 дэх заалт:

“1.6.9 Энэ журмын 3.1 дэх хэсгийн “Нэгж” гэж тус журмын 3.1.1, 3.1.11-ийн хувьд тус тус арилжааны банк, 3.1.3-ын хувьд Төв банк, 3.1.4-ийн хувьд аймаг, нийслэл, 3.1.5, 3.1.6, 3.1.7, 3.1.13-ын хувьд тус тус хуулийн этгээд, 3.1.8-ын хувьд хувь хүн эсхүл хуулийн этгээдийг хэлнэ.”

2/ 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.3 Нэгжид ногдох дээд хэмжээг тооцохдоо тухайн хөрөнгийн дүнг харгалзах нэгжид ногдох дээд хувиар үржүүлж тодорхойлно.”

3. Энэхүү тогтоолыг 2011 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Шаардлагад нэмэлт, өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлж ажиллахыг
Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН